



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2022/86/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт  
2022 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа  
Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа  
Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор: Б.Ганцэцэг  
Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Зөвлөмж .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СБТТ	Сурах бичиг түрээсийн тогтолцоо

## 1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 68  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.БАТТУЛГА  
ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>146,289,185.42</u></b>	<b><u>154,785,454.02</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	48,672.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	48,672.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	146,289,185.42	154,736,782.02
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,533,140.00	551,529.60
35130	Эм боох материал	1,533,140.00	551,529.60
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	13,793,482.00	13,793,482.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	130,962,563.42	140,391,770.42
35410	Бичиг хэргийн материал	635,450.00	1,112,597.00
35420	Аж ахуйн материал	107,300.00	183,594.00
35450	Барилгын засварын материал	95,000.00	267,600.00
35470	Бусад хангамжийн материал	130,124,813.42	138,827,979.42
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,554,399,932.80</u></b>	<b><u>2,580,669,264.49</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,554,399,932.80	2,580,669,264.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,443,649,599.52	2,469,145,264.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,395,505,613.84	2,463,800,823.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-91,314,980.40	-136,972,470.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,548,182.20	230,644,523.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-211,703,323.88	-217,891,550.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	188,960,055.00	201,594,483.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-122,517,249.06	-138,672,759.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,545,000.00	18,545,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,107,167.05	-14,246,167.09
39217	Ном	55,733,468.87	62,343,381.30
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	110,750,333.28	111,523,999.92
39301	Програм хангамж	608,000.00	1,508,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-227,666.72	-354,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	110,920,000.00	110,920,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,700,689,118.22</u></b>	<b><u>2,735,454,718.51</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>1,607,812.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	1,607,812.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	1,607,812.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,607,812.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,700,689,118.22</u></b>	<b><u>2,733,846,906.51</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,700,689,118.22	2,733,846,906.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	132,444,000.00	132,444,000.00
51101	Өмч: - төрийн	132,444,000.00	132,444,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,564,821,295.78	2,597,979,084.07
51210	Өмнөх үеийн үр дүн	2,564,821,295.78	2,564,821,295.78
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	33,157,788.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,423,822.44	3,423,822.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН</b>	<b><u>2,700,689,118.22</u></b>	<b><u>2,735,454,718.51</u></b>

ДҮН VI=IV+V

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,760,885,523.02</b>	<b>1,864,915,942.35</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,482,984,023.02</b>	<b>1,502,114,384.35</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	74,048,823.02	91,963,584.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,048,823.02	91,963,584.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,452,200.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69,596,623.02	91,963,584.35
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,408,935,200.00	1,410,150,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,408,935,200.00	1,410,150,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>277,901,500.00</b>	<b>362,801,558.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	672,000.00	17,522,358.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	672,000.00	17,347,358.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	175,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	277,229,500.00	345,279,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	277,229,500.00	345,279,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,743,965,969.62</b>	<b>1,831,758,154.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,743,965,969.62</b>	<b>1,831,758,154.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,693,511,621.65	1,780,751,677.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,146,026,138.51	1,169,338,812.00
210101	Үндсэн цалин	769,331,315.80	820,854,795.55
210102	Нэмэгдэл	260,939,168.31	259,098,607.80
210104	Урамшуулал	115,755,654.40	89,385,408.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	143,853,501.78	151,417,652.00
210201	Тэтгэврийн даатгал	97,980,301.78	110,135,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,468,300.00	9,758,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,174,600.00	7,726,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,293,700.00	1,945,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,936,600.00	21,852,952.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	255,777,439.64	319,079,600.00
210301	Гэрэл, цахилгаан	9,162,155.73	7,723,607.85
210302	Түлш, халаалт	237,617,934.91	301,267,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,997,349.00	10,088,992.15
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,798,001.47	23,933,839.33
210401	Бичиг хэрэг	2,065,577.68	1,971,913.00
210402	Тээвэр, шатахуун	5,054,632.00	1,605,583.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,564,558.39	1,326,228.68
210404	Ном, хэвлэл	4,512,200.00	5,970,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	472,700.00	371,537.00

**Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,128,333.40	12,688,257.65
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,683,798.00</b>	<b>5,603,418.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,454,120.00	4,907,540.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,229,678.00	695,878.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,665,825.00</b>	<b>26,141,770.00</b>
210604	Урсгал засвар	26,665,825.00	26,141,770.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>650,000.00</b>	<b>1,453,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	650,000.00	1,453,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,641,100.00</b>	<b>2,098,660.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,641,100.00	2,098,660.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,415,817.25</b>	<b>81,684,626.66</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,191,559.00	10,418,066.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,224,258.25	71,266,560.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,454,347.97</b>	<b>51,006,476.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,327,825.29</b>	<b>51,006,469.35</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,178,000.00	3,365,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,149,825.29	47,641,469.35
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,126,522.68</b>	<b>06.72</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,126,522.68	06.72
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>16,919,553.40</u></b>	<b><u>33,157,788.29</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>16,919,553.40</u></b>	<b><u>33,157,788.29</u></b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	2,564,821,295.78	00.00	2,700,689,118.22
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	2,564,821,295.78	00.00	2,700,689,118.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	2,564,821,295.78	00.00	2,700,689,118.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,157,788.29	00.00	33,157,788.29
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	132,444,000.00	3,423,822.44	2,597,979,084.07	00.00	2,733,846,906.51

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,691,288,900.00</u></b>	<b><u>1,772,952,358.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>1,413,387,400.00</u></b>	<b><u>1,410,150,800.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,452,200.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,452,200.00	00.00

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,452,200.00	00.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	1,408,935,200.00	1,410,150,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,408,935,200.00	1,410,150,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>277,901,500.00</b>	<b>362,801,558.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	672,000.00	17,522,358.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	672,000.00	17,347,358.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	175,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	277,229,500.00	345,279,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	277,229,500.00	345,279,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,688,368,226.00</b>	<b>1,762,875,887.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,688,368,226.00</b>	<b>1,762,875,887.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,639,119,962.32</b>	<b>1,710,644,480.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,146,692,105.18	1,167,731,000.00
210101	Үндсэн цалин	769,997,282.47	819,246,983.55
210102	Нэмэгдэл	260,939,168.31	259,098,607.80
210104	Урамшуулал	115,755,654.40	89,385,408.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	143,353,500.00	151,459,300.00
210201	Тэтгэврийн даатгал	97,480,300.00	110,135,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,468,300.00	9,758,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,174,600.00	7,726,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,293,700.00	1,945,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,936,600.00	21,894,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	269,052,472.64	319,079,600.00
210301	Гэрэл, цахилгаан	9,162,155.73	7,723,607.85
210302	Түлш, халаалт	249,341,799.91	301,267,000.00
210303	Цэвэр, бохир ус	10,548,517.00	10,088,992.15
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,607,219.50	25,312,917.68
210401	Бичиг хэрэг	1,437,100.00	2,099,961.00
210402	Тээвэр, шатахуун	5,189,500.00	1,605,583.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,889,999.50	1,284,618.68
210404	Ном, хэвлэл	4,812,100.00	5,805,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	472,700.00	371,537.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,805,820.00	14,146,018.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,992,800.00	6,444,899.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,570,200.00	4,131,299.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,422,600.00	2,313,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,696,165.00	26,199,600.00
210604	Урсгал засвар	29,696,165.00	26,199,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	650,000.00	1,453,300.00
210702	Дотоод албан томилолт	650,000.00	1,453,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,</b>	6,268,100.00	2,541,994.00

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,268,100.00	2,541,994.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,807,600.00	10,421,869.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,807,600.00	10,421,869.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>49,248,263.68</b>	<b>52,231,406.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	41,121,741.00	52,231,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,405,500.00	4,600,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,716,241.00	47,630,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,126,522.68	06.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,126,522.68	06.72
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,920,674.00</u></b>	<b><u>10,076,471.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,785,180.00</b>	<b>10,076,471.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,785,180.00</b>	<b>10,076,471.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	2,785,180.00	10,076,471.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,785,180.00	10,076,471.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-2,785,180.00</u></b>	<b><u>-10,076,471.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	135,494.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,755,430,000.00	1,755,429,993.28
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,755,430,000.00	1,755,429,993.28
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,703,468,600.00	1,703,468,593.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,167,731,000.00	1,167,731,000.00
210101	Үндсэн цалин	850,447,200.00	819,246,983.55
210102	Нэмэгдэл	230,373,800.00	259,098,607.80
210104	Урамшуулал	86,910,000.00	89,385,408.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	151,459,300.00	151,459,300.00
210201	Тэтгэврийн даатгал	110,135,400.00	110,135,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,758,000.00	9,758,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,726,100.00	7,726,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,945,200.00	1,945,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,894,600.00	21,894,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	319,079,600.00	319,079,600.00
210301	Гэрэл, цахилгаан	7,764,800.00	7,723,607.85
210302	Түлш, халаалт	301,267,000.00	301,267,000.00

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	10,047,800.00	10,088,992.15
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,591,500.00	20,362,499.68
210401	Бичиг хэрэг	1,906,600.00	1,959,961.00
210402	Тээвэр, шатахуун	1,606,400.00	1,605,583.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,126,800.00	1,284,618.68
210404	Ном, хэвлэл	762,600.00	752,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	371,537.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,617,100.00	14,388,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,380,900.00	6,609,899.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,902,300.00	4,131,299.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,478,600.00	2,478,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,199,600.00	26,199,600.00
210604	Урсгал засвар	26,199,600.00	26,199,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	953,300.00	953,300.00
210702	Дотоод албан томилолт	953,300.00	953,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,572,000.00	2,571,994.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,572,000.00	2,571,994.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8501400.00	8501400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,501,400.00	8,501,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	51961400.00	51961400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,961,400.00	51,961,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,330,800.00	4,330,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,630,600.00	47,630,600.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,755,430,000.00	1,755,429,993.28
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,410,150,800.00	1,410,150,793.28
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,410,150,800.00	1,410,150,793.28
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	345,279,200.00	345,279,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	345,279,200.00	345,279,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	88.00	88.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	68.00	68.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>17,522,358.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>17,522,358.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	17,252,358.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,899,858.00
210401	Бичиг хэрэг	140,000.00
210404	Ном, хэвлэл	5,775,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,984,658.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	500,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	35,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4617500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,617,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	270000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	270,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	270,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	17522358.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	17,522,358.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,347,358.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, бараа материал, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн зорилго нь Бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад чиглэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,736.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34.3 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	0.00	0.05	0.05

<b>Бараа материал бэлтгэх урьдчилгаа</b>	-	-	-
<b>Бараа материал</b>	146.29	155.27	8.97
<b>Үндсэн хөрөнгө</b>	2,554.40	2,579.71	25.31
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,700.69</b>	<b>2,735.02</b>	<b>34.33</b>
<b>Өр төлбөр</b>	0	1.60	1.60
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	2,700.69	2,733.42	32.73
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,700.69</b>	<b>2,735.02</b>	<b>34.33</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,579.71 сая төгрөг болж 25.31 сая төгрөгөөр өссөн. Үндсэн хөрөнгийн данс өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан “3х3 сагсан бөмбөгийн стандарт талбай” гол нөлөөлжээ. Мөн тайлант онд төсвийн хөрөнгөөр 9.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 104.0 сая төгрөгөөр буюу 1.06 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлогын данс байна. Тодруулбал тайлант онд талбайн дахин хэмжилт хийж спорт заалны талбай нэмэгдсэн, мөн 2021 онд ковид-19 цар тахлын улмаас 9 сарын 15-ны өдрөөс эхлэн халаалт тавьсантай холбоотойгоор түлш халаалтын зардал нэмэгдэж урсгал үйл ажиллагааны санхүүжилт 68.0 сая төгрөгөөр өссөн байна. Харин нэмэлт санхүүжилтийн орлого 16.8 сая төгрөгөөр өсөж, тайлант үед 17.5 сая төгрөг болсон байна. Энэ нь 10.6 сая төгрөгийн “Цахим хөтөч-Сурагчийн хөгжилд” төсөл, 6.7 сая төгрөгийн түрээсийн номын төлбөр зэргээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 88.2 сая төгрөг буюу 1.05 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан түлш халаалт, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал зэрэг зардлууд байна. Тайлант онд талбайн дахин хэмжилт болон ковид-19 цар тахалтай холбоотой 9 сарын 15-ны өдрөөс эхлэн халаалт тавьсантай холбоотойгоор түлш халаалтын зардал 63.6 сая, Монгол улсын Засгийн газрын 237 дугаар тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 1500 төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотой төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 8.5 сая, сурагчдын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм сахихтай холбоотой 2.5 сая төгрөгөөр тус тус өссөн зэргээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,848.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,848.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 348.8 сая төгрөгөөр бууруулж 1,499.8 сая төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 255.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Төсвийн төслөөс тайлант оны төсөв 93.2 сая төгрөгөөр буурч

батлагдсан боловч тухайн байгууллагын 2021 онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 арга хэмжээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ны хэрэгжилт 91.2 хувьтай байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,755.4 сая төгрөгийн төсөв баталснаас 1,410.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 345.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,410.1 сая, орон нутгийн төсвөөс 345.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаа болон хувьсах зардалд зарцуулсан байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд “Цахим хөтөч-Сурагчийн хөгжилд” төслийн 10.6 сая, түрээсийн номын 6.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, уг төслийн хүрээнд интерактив цахим цуврал хичээлд 2.9 сая, төслийн хүрээнд орчны тохижилт, хөрөнгө оруулалт 7.7 сая, түрээсийн номын төлбөр 6.8 сая СБТТ-эргэлтийн санд төвлөрүүлжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Сүхбаатар аймгийн ХААН банкнаас 68.3 сая төгрөгийн 150x150x3.5 мм ганжуулсан шилэн стандартын шийд, 200W нарны зай хураагуураар ажилладаг гэрэлтэй 19.4x15.2 м хэмжээтэй хашаалсан талбай бүхий “3x3 сагсан бөмбөгийн стандарт талбай” шинээр хүлээн авсан байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 6 арга хэмжээний хэрэгжилт 91.2 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа хоцорсон 8 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төсвийн зарцуулалт нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 2.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 2.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 76 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

- *Багш нарын ээлжийн амралт, цалин хөлсийг давхардуулан олгосон 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлүүлсэн;*

- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү бодож олгосон 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлүүлсэн;
- Хоолны зардлыг зориулалт бус зарцуулсан 2.2 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлсэн;
- Өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу ажилласан байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн гэж үзлээ.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 642.4 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 636.1 сая төгрөгийн 3 алдаа зөрчлийг залруулж, 6.3 сая төгрөгийн 4 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Засгийн газрын 43 дугаар тогтоолтой холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Төсвийн зарцуулалтад Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1. “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.2. “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх”, 1.8. “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах” заалтыг мөрдөөгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны 388 тоот тогтоол “Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээ” болон төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа чиглэлийг баримтлан, биелэлтийг ирүүлэх

#### **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 86 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

**3. Бараа материалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 6 нэр төрлийн 6.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэж дансны үлдэгдэл, тодруулгын батламж мэдэгдлийг хангаагүй байна. Энэ нь УСНББОУС-ын "17-Үндсэн хөрөнгө" дахь 12-ын (а,б) заалт, НББ тухай хууль /19.1.2 батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;/ Төсвийн тухай хууль/ 26.1.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө/ гэсэн заалттай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын дансанд бүртгэлтэй 6 нэр төрлийн 6.3 сая төгрөгийн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, шилжүүлэн бүртгэж зөрчлийг арилгах

**4. Шилэн данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт**

Шилэн дансны цахим хуудсанд 150 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нийт 2,060.3 сая төгрөгийн 57 мэдээллийг ил тод байршуулахаас 947.7 сая төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй, байгаа мэдээллийг байхгүйгээр мэдээлсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

			/сая төгрөгөөр/
д/д	Аудитад хамрагдсан	Нийт	Үүнээс

Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	байгууллагын нэр	алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	8	7.6	4	1.3					4	6.3